



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/233

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран зохион байгуулах "Судалгааны арга зүй" сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын  
19 өдрийн тушаалын нэгдүгээр хавсралт

А/233



## “СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ

### Үндэслэл:

Дэлхий дахинаа мэдлэгт суурилсан хөгжлийн чиг хандлага, нотолгоонд суурилсан анагаах ухааны тухай ярьж, эрдэм судлалыг ихээхэн чухалчилдаг боллоо.

Монгол улсын засгийн газар, эрүүл мэндийн салбарын стратегийн тэргүүлэх чиглэлд энэхүү асуудал хөндөгдөн, эрдэм судлалын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх талаар бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Энэ нь анагаахын шинжлэх ухаан, технологийн тулгамдсан асуудлыг судлан, нотолгоонд суурилан оновчтой бодлого боловсруулан, хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох, судалгааны үр дүнг нэвтрүүлэх боломжийг олгох юм.

Энэхүү боломжийг хэрэгжүүлэхэд салбарын эмч, мэргэжилтний судалгаа хийх мэдлэг, ур чадвар ихээхэн дэмжлэг болох нь гарцаагүй. Иймд бид эмч, эмнэлгийн мэргэжилтний шинжлэх ухаанч судалгаа хийх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах шаардлагатай байна.

### Сургалтын зорилго:

Төвийн мэргэжилтнүүдийн судалгаа хийх мэдлэг, ур чадварыг сайжруулах

### Сургалтын зорилт:

- Эпидмиологийн болон Статистик судалгааны арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх
- Судалгааны дизайн боловсруулах, түүвэр хийх, тайлан бичих ур чадварт суралцах

### Хичээлийн зориулалт:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 20 мэргэжилтэн

### Сургалт явуулах газар:

Эрүүл мэндийн хөгжлийн төв

### Сургалтын хугацаа:

2017 оны 12 сарын 28 – 2018 оны 1 сарын 28

### Агуулгын багтаамж:

3.0 багц цаг

### Зайлшгүй эзэмших мэдлэг:

Судалгааны асуудал, сэдвийг сонгох, тулгамдсан асуудлыг тодорхойлох, таамаглал дэвшүүлэх, эпидмиологийн болон статистик судалгааны арга зүйн мэдлэг эзэмшинэ.

### Эзэмшвэл зохих чадвар:

Судалгааны ёс зүй, судалгааны үнэн магадлалыг хангасан түүвэрлэлт хийх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, судалгааны арга, аргачлал боловсруулах, эрүүл мэндийн судалгааны төсөл бичих арга зүй болон эрдэм шинжилгээний өгүүлэл бичих мэдлэг эзэмшинэ тайлан бичих ур чадварт суралцана.

**Зайлшгүй эзэмших хандлага:**

Судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмж нь нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гол мэдээлэл бөгөөд шийдвэр гаргах үндсэн хэрэглэгдэхүүн гэдгийг мэргэжилтэн бүр мэддэг, зөв хандлагатай болно.

**Сургалтын хэрэглэгдэхүүн:**

Эрүүл мэндийн байгууллагуудын судалгааны төлөвлөгөө, хийгдсэн судалгааны тайлан, материалууд, бүлгээр ажиллах цаас, харандаа, өнгийн цаас, компьютер, LSD дэлгэц, цагаан самбар, самбарын үзэг

**Сургалтын арга зүй:**

Онолын мэдлэг олгох богино хугацааны лекц, дадлага, багаар ажиллах, бүлгийн хэлэлцүүлэг хийнэ.

**“Судалгааны арга зүй” сургалтын төлөвлөгөө**

№	СЭДЭВ	Лекц	Семинар
1.	Дотоодын болон Олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэц, бичих арга зүй, тавигдах шаардлагууд	2	-
2.	Эрүүл мэндийн судалгааны төсөл бичих арга зүй	2	4
3.	Судалгааны мэдээ материал цуглуулах тоон ба чанарын аргууд, асуумж боловсруулах арга зүй	2	4
4.	Эрүүл мэндийн судалгаанд эпидмиологийн судалгааны аргуудыг хэрэглэх нь, агшингийн ба дескриптив судалгааны аргууд	2	4
5.	Тохиолдол хяналтын ба Когорт судалгаа, бүлгүүдийн сонголт, ижилсүүлэлт, түүвэрлэх арга зүй, үр дүнг тооцох	2	4
6.	Дескриптив статистик, төвийн хандлага, хэлбэлзлийн үзүүлэлт, тархалтын хэлбэр	2	4
7.	Түүвэр, түүврийн хүрээ, түүврийн хэмжээг тодорхойлох	2	4
8.	Таамаглал дэвшүүлэх, I ба II төрлийн алдаа, дунджийг шалгах аргууд: т тест	2	4
9.	Статистик боловсруулалтын программд өгөгдөл оруулах, хувиргах, өгөгдлийн менежмент	2	8
10.	Нийт цаг	12	36
11.	Нийт кр	1.5	1.5


**Сургалтын үр дүн:**

Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд өөрийн ажлын байран дээрх өгөгдлийг ашиглаж судалгаа хийх судалгааны арга аргачлалтай болох бөгөөд ажлын байран дээрх судалгааг хийж шийдвэр гаргагчдад нотолгоотой мэдээллээр хангана.

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын  
19 өдрийн Шушаалын хоёрдугаар хавсралт

4/233

"СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ" СУРГАЛТЫН ТӨСӨВ



	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Сургалтын төлбөр	20 хүн 3 кр	63,000	3.780.000
2	Сургалтын цайны зардал	9 өдөр 20 хүн	2000	360.000
3	Бичиг хэргийн зардал	20 хүн	10.000	200,000
	<b>НИЙТ</b>			<b>4.340.000</b>